

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төслийн нэр:	3
1.2 Төслийн зорилго:	3
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:	3
1.4 Төслийн хүчин чадал:	3
1.5 Үйлдвэрийн ашиглалтын технологи:	3
1.6 Эцсийн бүтээгдэхүүн:	5
1.7 Төслийн дэд бүтэц:	6
1.7.1 Барилга байгууламж:	6
1.7.2 Усан хангамж:	6
1.7.3 Цахилгаан хангамж:	7
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	8
2.1 Төслийн байршил:	8
2.2 Төслийн физик газарзүй:	9
2.3 Уур амьсгал:	10
2.5 Агаарын температур:	10
2.6 Хур тунадас:	10
2.7 Агаарын чанар:	11
2.8 Гадаргын ус:	11
2.9 Гадаргын доорх ус:	12
2.10 Хөрсөн бүрхэвч:	13
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	14
3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөө:	14
3.2 Хөрс ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөө:	14
3.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөө:	15
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	16
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	25
БҮЛЭГ 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	25

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	28
БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	31
БҮЛЭГ 13. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ	34
БҮЛЭГ 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ.....	36

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр:

“Хэцүү цав” нэртэй хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах төсөл

1.2 Төслийн зорилго:

“Хэцүү цав” нэртэй хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах төсөл

1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:

Хүснэгт №. 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Боржигт” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011126054
Регистрийн дугаар	2603365
Хаяг	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Гурвалжингийн, Эс Би төвийн-305-тоот
Утас	99059583

1.4 Төслийн хүчин чадал

MV-012118 тоот тусгай зөвшөөрлийн талбайн “Хэцүү цав”-ын хайлуур жоншны ордын нөөцийг Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2010 оны 06-р сарын 04-ний өдрийн хурлын хуралдааны ХХ-07-05 дугаар дүгнэлээр Хэцүү цавын хайлуур жоншны нөөцийг бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 81.3%-ийн дундаж агуулгатай 108.2 мян.тн 87.9 мян.тн эрдэсээр хүлээн авсан байна.

“Хэцүү цав” хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах бөгөөд Уулын ажлыг газрын дор ажиллах далд уурхайн хэсэгт 7 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр, газрын дээр ажиллах хэсэгт 8 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр сонгон жилд 300 хоног ажиллахаар төлөвлөсөн байна.

1.5 Үйлдвэрийн ашиглалтын технологи:


Тус ордын бодитой В зэрэглэлээр нөөц тогтоогдсон хүдрийн биетийн суналын дагуух гадаргуугийн өндөржилт нь 1150.0 м-ээс 1162.0 м-ийн хооронд хэлбэлздэг бөгөөд эндээс харахад хүдрийн биет нь тэгш гадаргуутай учир ордыг босоо гол амаар нээх нөхцлийг бүрдүүлж байгаа юм.Тус үйлдвэрийн технологи нь тариа хүлээн авах хэсэг, тариа цэвэрлэх хэсэг, тээрэмдэх хэсэг, савлах хэсэг гэсэн 4

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

үндсэн хэсгээс бүрдэнэ. Үйлдвэрийн технологийн схемийг дэлгэрэнгүйгээр харуулсан байна.

“Хэцүү цав” хайлуур жоншны ордын В зэрэглэлээр тогтоогдсон нөөцийг эхний ээлжинд ашиглахаар тусгаж байна. Дээрх хүдрийн биет нь 75° уналтай, 1.4 м дундаж зузаантай, ашиглалтын гүн дундажаар 75.0 м байна. Ордын уул-геологийн нөхцлөөс харахад хүдэр хоршоолох ашиглалтын систем хамгийн тохиромжтой байна.

Хүдэр хоршоолох ашиглалтын систем хэрэглэх үед блок хоорондын хамгаалалтын цул, блокийн дээд хамгаалалтын цулыг үлдээх бөгөөд хүдэр нураалтын ажлыг 1.2-1.4 м өндөртэй хэвтээ үеэр зохион байгуулна. Хүдэр хоршоолох ашиглалтын систем нь аваар осол багатайгаас гадна мөрөгцөгийн ажилчны хөдөлмөрийн бүтээмж өндөр, ашиглалтын хаягдал, бохирдол бага байдаг.




Зураг № 1 Хүдэр хоршоолон нураах ашиглалтын систем

1.6 Эцсийн бүтээгдэхүүн:

“Боржигт” ХХК нь Геологийн төв лабораторит Хэцүү цав ордын баяжигдах шинж чанарын судалгаа, туршилтыг хийж гүйцэтгүүлсэн байна. Туршилтаас тухайн ордын дээжийг баяжуулж өндөр чанарын флотацийн баяжмал гарган авах боломжтой нь тогтоогдсон байна. Гэвч тухайн орд нь флотацийн баяжуулах үйлдвэр байгуулахад нөөц багатай, дэд бүтэц-ээс хол, гидрогеологийн нөхцөл хүнд тул эдийн засгийн хувьд ашиггүй юм. Иймд баяжуулалтын технологийг гар аргаар ангилан ялгах аар сонгов .

Технологийн туршилт судалгаагаар тухайн ордын хүдрийг нэг шатны бутлуураар бутлан доргиурт шигшүүрээр шигшин ангилж, бутлагдсан хүдрийг нэгэн жигд ширхэглэл бүхий фракцуудад хуваан гар аргаар ангилан ялгах бүрэн боломжтой нь тогтоогдсон.



Зураг № 2 Баяжуулах технологийн схем

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.7 Төслийн дэд бүтэц:

1.7.1 Барилга байгууламж

Уурхайд нийт 72 хүн ажиллахаар байна. Тус уурхайн барилга байгууламж нь үйлдвэрлэлийн барилга байгууламж ба ажиллагсдын тосгон гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Төслөөр дараах барилга байгууламжуудыг барихаар тусгаж байна.

Хүснэгт №. 2 Төслийн барилга байгууламж

Барилга байгууламжийн нэр	Материал
а. Үйлдвэрийн барилга байгууламж	
Контор	сэндвич
Засвар механикийн цех	сэндвич
Баяжуулах цехийн барилга байгууламж	сэндвич
Сэлбэгийн агуулах	сэндвич
Гараж	хоосон чулуу
Тэсрэх материалын агуулах	тоосго
ШТМ-ын агуулах	емкость
Гол амны байгууламж	мод, тоосго
б. Иргэний барилга байгууламж	
Ажилчдын байр	сэндвич
Хоолны байр	сэндвич
Халуун ус, жорлон	сэндвич

Зам тээвэр: Хайлуур жоншны эрэлт хэрэгцээ их байгаа учраас бүтээгдэхүүн борлуулахдаа уурхай дээрээс худалдах нөхцөлтэй учир гадаад тээвэр хийхгүй.

Усан хангамж: Усны үндсэн хэрэглэгч нь уурхайн тосгон ба далд уурхайн өрөмдлөгийн ажил байна. Далд уурхайн усан хангамжийг өөрийн эзэмшлийн гүний худгаас хангана.

1.7.2 Усан хангамж:

Усны эх үүсвэр:

- Өрөмдмөл гүний худаг
- Усны ундарга 1.7 л/сек

Уурхайн ашиглалтын хүрээнд дараах усны хэрэглэгч байна. Үүнд:

- Ажилчдын унд ахуйн хэрэглээ
- Уурхайн зам талбайн тоосжилт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

- Нөхөн сэргээлт

Ус ашиглах:

Ахуйн зориулалтаар: Усыг хоол унданд, эрүүл ахуйн шаардлагын дагуу ажилчдын халуун усны газарт, хүйтний улиралд ажлын байр болон орон сууцны халаалтын зориулалтаар усыг хэрэглэнэ.

Нөхөн сэргээлтийн ажлын зориулалтаар: Эвдрэлд өртсөн талбайг нөхөн сэргээж зүлэгжүүлсэн талбайг болон мод, бут ургамлыг услах зориулалтаар хэрэглэнэ.

Зам усалгаа, тоос дарах зориулалтаар: Уурхайн гадна, доторх замыг тогтмол услах мөн тоног төхөөрөмж ажиллаж буй талбайг услах зэрэгт тус тус хэрэглэнэ.

Хүснэгт №. 3 Нийт усны тооцоо

№	Ус ашиглалтын хэлбэр	Усны эх үүсвэр	Ашиглах усны хэмжээ	
			Хоног М³	Жил М³
1	Ажилчдын унд ахуйн усны хэрэглээ	Уурхайн гүний худаг	10.65	3195
2	Зам усалгаа, тоос дарах		10.0	1200.0
Нийт			20.65	4395

1.7.3 Цахилгаан хангамж

Цахилгаан хангамж: Тус уурхайн цахилгаан тулд “Боржигт” ХХК нь дизел цахилгаан үүсгүүр ашиглаж уурхайн цахилгаан хэрэглээг хангана.

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН,
НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ**

2.1 Төслийн байршил:


“Хэцүүцав” нэртэй хайлуур жоншны орд газар нь Өвөрхангай аймгийн Төгрөг сумын нутагт оршино. Тус орд газрын талбай нь (цаашид “Хэцүүцав” гэх) Улаанбаатар хотоос баруун урагш 620км, Арвай хээрээс 200км, Төгрөг сумын төвөөс 100км, Хурцын тэвшээс баруун-хойш 12км, Хэцүүцавын худгаас баруун тийш 2км зайд тус тус алслагдсан бөгөөд газарзүйн байрлалын хувьд нилээд алслагдсан дэд бүтэц хөгжөөгүй нутагт байрладаг.

“Хэцүүцав” хайлуур жоншны ордын 230 гектар хэмжээтэй тусгай зөвшөөрлийн талбайн цэгүүдийн солбицол нь:

Хүснэгт №. 4 Төслийн талбайн координат

№	Уртраг	Өргөрөг
1	103° 23' 35.92"	44° 57' 1.48"
2	103° 23' 35.92"	44° 58' 1.48"
3	103° 23' 14.19"	44° 58' 1.48"
4	103° 23' 14.2"	44° 58' 0.97"
5	103° 23' 7.2"	44° 57' 52.29"
6	103° 22' 55.93"	44° 57' 43.97"
7	103° 22' 55.93"	44° 57' 41.48"
8	103° 22' 53.21"	44° 57' 41.48"
9	103° 22' 40.18"	44° 57' 25.33"
10	103° 22' 34.36"	44° 57' 17.53"
11	103° 22' 33.54"	44° 57' 3.8"
12	103° 22' 33.36"	44° 57' 1.48"

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг № 3. Төслийн талбайн сансрын зураг

2.2 Төслийн физик газарзүй:

Газарзүйн мужлалын хувьд Нууруудын хотгорын (Долино Озёрский впадин) зүүн урд төгсгөл, Онгийн голын хотгорын баруун хэсэгт байрлана. Энэ нутгийн гадаргын хөгжилд мезозойн үеэс уламжлагдан, палеоген-неогений үед үргэлжилсэн нуурын гаралтай, эх газрын тунамал хуримтлал бүхий нууруудын орчин голлон нөлөөлсөн бөгөөд гадаргуугийн хэлбэр дүрсэд тэгш талархаг болон жижиг толгодлог гадаргуу онцлогтой.

Байрлалын хувьд Нууруудын хотгорын зүүн хэсэгт хамаарагдах тул тал хээр, говийн уур амьсгал, ургамал, ан амьтан зонхилдог. Хангайн өмнөд пеннепенжсэн гадаргуугаас Нууруудын хотгорын баруун хойш сунаж ухаа толгод, тэгш талархаг дэвсэг, шал хөндийнүүдэд шилжсэн хэсгийн онцлог болох 1200-1500м орчим өндөржилтэй жижиг толгодлог болон дэвсэг, тэгш талархаг гадаргуу зонхилно. Тусгай зөвшөөрлийн талбайгаас урагш 12км-т байрлах Хуцын тэвш уул 1346,3м өндөртэй энэ хэсгийн хамгийн өндөр уул болно.

2.3 Уур амьсгал:

Төслийн талбай нь уур амьсгалын хувьд дулаан зунтай чийг дутмаг мужид багтана. Бүх нутгаар агаарын хэм харьцангуй жигд байдаг. Ургамалшил тачирхан, чулуурхаг буюу элсэрхэг гадаргатай тул наранд халж агаарын хэмийг нэлээд дээшлүүлдэг. Хамгийн их хүйтрэлт 1-р сард, хамгийн их халуун 7-р сард болдог. Өвөл 20–15° хааяа 36-40° хүрч хүйтэрнэ.

2.5 Агаарын температур:

Тус ордын талбай нь Монгол орны нутаг дэвсгэрийн бусад хэсгийн адил өвөлдөө хүйтэн, зундаа халуун, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Жилийн дундаж температур -20 ба дундаж температурын хэлбэлзэл өвөлдөө -20⁰, зундаа +20⁰ байдаг


2.6 Хур тунадас:

Зуны улиралд өдрийн дундаж температур +210 ба заримдаа +300 гарч халдаг. Жилийн хур тунадсын ихэнхи нь 6-аас 9-р сарын хооронд унах бөгөөд дундаж нь 100-250мм байна. Хаврын саруудад ихээхэн хүчтэй салхилж, хуурайшил ихтэй. Талбайн хэмжээнд өвөлдөө цас бага унах ба цасан бүрхүүлийн зузаан гуу жалгандаа 20-30см хүрнэ. Нууруудын хотгорын гол онцлог болсон баруун хойноос зүүн урагш чиглэлийн байнгын салхи, шуургатай ба шуурганы хүч хаврын улиралд 40м/сек хүрэх тохиолдол цөөнгүй бөгөөд Арц Богдын арын хоолойн хэмжээнд байрлаж байгаагийн хувьд салхи шуурганы гол шугам дээр байгаа юм.

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2.7 Агаарын чанар:

Төслийн талбайд агаарын чанарын харуул байхгүй бөгөөд нийт талбайн агаарын чанарын хэв шинжийг Сайншанд суманд байрлах харуулын мэдээгээр авлаа. Манай төслийн талбай нь ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй агаарын чанарын хувьд өөрчлөлт ороогүй тул агаарын чанарын хэмжилт хийх шаардлагагүй гэж үзэв. Сайншанд сумын агаарын чанарын харуул нь агаарт агуулагдах хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/-ийн хэмжээг ажлын өдрүүдэд, тоосонцор /PM₁₀ /-ын хэмжээг 7 хоногт 2 удаагийн давталттайгаар хэмжин тодорхойллоо. Өнгөрсөн 7 хоногийн хүхэрлэг хий, азотын давхар исэл, тоосонцорын агууламжийг тус бүрд нь хүлцэх хэмжээтэй харьцуулсныг графикаар харуулав.



Зураг № 4 Хүхэрлэг хий болон Азотын давхар ислийн агууламж

2.8 Гадаргын ус:

Төслийн талбайтай очиж танилцахад талбайн ойр орчим гадаргын ус буюу гол, горхи, булаг шанд байхгүй байсан. Уг сав газар нь ус зүйн сүлжээний нягтшил 0.01 км/м²-аас бага гадаргын усны эх үүсвэр хомс голчлон зуны хур борооны дараа түр зуурын урсацтай болдог цөөн тооны горхи, хуурай сайруудтай. Эдгээр нь улирлын чанартай жижиг нуур болон давстай нуурын систем рүү цутгадаг болно. Зуны улиралд эрчимшил ихтэй хур бороо орсны дараа хуурай сайр, гуу жалга, хөндийгөөр ширүүн урсацтай үер үүсэж, ёроолын хурдас хагшаасыг угааж ихээхэн эвдрэл үүсгэдэг. Хавраас намрын улирал хүртэл үер 4-6 удаа давтагдах ба үргэлжлэх хугацаа 30-90 минут гэж тогтоогдоод байна.

2.9 Гадаргын доорх ус:

Тусгай зөвшөөрлийн талбай нь Монгол орны усны сав газрын ангиллаар Онги голын савд хамаарах ба тухайн дүүрэгт урсгал ус, гол, горхи булаг шанд байхгүй. Хайгуулын ажлын явцад гидрогеологийн тусгайлсан судалгаа хийгдээгүй өмнөх шатны судалгааны өрөмдлөгийн явцад цооногт ус илрээгүй.

Дүүргийн хэмжээнд урьд жилүүдэд явуулсан гидрогеологийн судалгаагаар орчмын 2900 км.кв талбайд 74 худаг, 24 булаг шанд, 2 өрөмдмөл худаг тэмдэглэсэн байдаг ба Ахар уул орчим боржингийн биетэд өрөмдсөн №46 цооногт 60.25 м гүнд, 15 л/сек ундаргатай уст үе илэрсэн нь А.Я.Аносов, А.Г.Аносова нарын тодорхойлсноор ундны хэрэгцээнд хэрэглэж болох сайн чанартай гэсэн дүгнэлт гарсан байна.

Ордын ойролцоо гадаргуугийн ус байхгүй. Хайгуулын өрөмдлөгийн цооногуудад 20-30 м-ийн гүнд гүний ан цавын болон нүх сүвийн усны түвшин тогтоогдоогүй болно. Энэ нь ашиглалтын үеийн усны шүүрэл маш бага байх, уул техникийн хувьд хүндрэл учруулахааргүй гэж үзэж болно.

Харин ордын ойролцоо Хэцүүцав худаг зэрэг ундарга сайтай худгуудтай ба эдгээрээс техникийн болон ахуйн хэрэгцээний усаа авах боломжтой.

Мөн талбайн гадна талд ордоос 1км хүрэхгүй зайд 5 л/сек ундаргатай сайн чанарын устай өрөмдмөл худаг ажилладаг ба энэ худаг ойр орчноо хангадаг. Ордын ойр орчим ажиллаж буй ганц нэг худгуудын үзүүлэлт болон өмнөх судлаачдын гаргасан зөвлөмжөөс үзэхэд орд орших талбайд цагаанцав формацын вулканоген-туфоген хурдаст 60.0 м хүртэл гүнд уст үе тогтоогдох боломжтой гэсэн байдаг.

Хэцүүцавын хайлуур жоншны ордын хэмжээнд гүйцэтгэсэн хайгуулын ажлын явцад гидрогеологийн тусгайлсан судалгаа хийгээгүй. Өрмийн цооног ба уулын босоо малталт (шурф)-д ажлын явцад газрын доорх усны шүүрэлт ажиглагдаагүй ба үүгээр гидрогеологийн ажиглалт хязгаарлагдсан.

2.10 Хөрсөн бүрхэвч:

Хөрс судлаачийн дүгнэлтээр: Хөрсний шинж чанарын хувьд маш сийрэг, чийгийн хангамж багатай, чулуурхаг цайвар бор өнгийн хээрийн хэв шинжид хамаарах элсэрхэг хөрс зонхилсон байх ба хөрс нь байглийн элэгдэл эвдрэлд бага зэрэг өртсөн, хүний болон техник технологийн нөлөөнд өртөөгүй байна.

Лабораторийн задлан шинжилгээ: Тус талбайд 2020 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр судалгаа явуулж гадаргын төрх байдлыг тодорхойлон хөрсний 1 цэгийн зүсэлт хийж агрохимийн дээжийг авч “ХААИС-ийн Хөрс-Агрохимийн лабораторид хөрсний задлан шинжилгээнд хамруулсан. Хөрсний задлан шинжилгээг доорх аргаар тодорхойлов.

2.11 Ургамлан бүрхэвч:

Төсөл хэрэгжих талбай нь чулуурхаг хээрийн болон говь цөлийн хээрийн бүсийн ургамал зонхилдог байна. Үүнд: Хазаар өвст-таана хялганат бүлгэмдэл зонхилсон байна.

Байгаль орчны төлөв байдлын суурь судалгааны ажлын хүрээнд Өвөрхангай аймгийн Төгрөг сумын нутаг дэвсгэрт орших “Хэцүү цав” хайлуур жоншны ордын талбайд очиж ургамлын судалгааг явуулахад төсөл хэрэгжих талбай нь хялгана, хазаар өвс, таана зэрэг бүлгэмдэлтэй хээрийн хэв шинжийг харуулсан байсан. Талбайд ургамалжилт 30-40% дунд зэрэг талхлагдсан ба халцгай газрын эзлэх хувь 35%, үлдсэн 25%-ийг хад чулуу эзэлж байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөө:

Уг төсөл хэрэгжих талбай нь хүний суурьшлын бүсээс алслагдмал бүс буюу Алтанширээ сумын төвөөс хойд зүгт 20 км зайтай, төслийн талбайн эргэн тойронд хайлуур жоншны хэд хэдэн уурхай байгаа болон төслийн талбайд өмнө нь бичил уурхайчид олборлолт явуулдаг байсан тул агаар орчинд нөлөөлж бохирдуулах тоос, хүнд машин механизмуудын утаа зэргээр дунд зэргийн бохирдсон байна.

Агаар орчныг бохирдуулах үндсэн эх үүсвэрийг байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гэж 2 ерөнхий хэсэгт хувааж үзнэ. Агаарын бохирдолын нилээд аюултай эх үүсвэрт хүний үйл ажиллагаанаас хамааралтай бохирдолт ордог ба энэ нь ихэвчлэн үйлдвэрлэлтэй холбоотой.

Далд уурхайн олборлолт, хөрс хуулалт, тээвэрлэлт, дэд бүтцийн барилга байгууламжуудыг барих явцад үүсэх тоосжилт, тээврийн хэрэгслээс гарах хорт утаа агаарт хаягдах, болон тэдгээрээс агаарын дуу чимээний бохирдол үүсэх зэрэг нөлөөлөлд өртөнө.

Төслийг эхлүүлсэнээр агаар орчны чанарт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь дараах эх үүсвэрээс үүснэ. Үүнд:

- Уурхайн байгуулалтын үеийн газар шорооны ажил
- Уурхайн болон баяжуулах үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаа
- Авто техникийн утаа
- Тэсэлгээ хийх зэрэг болно.

3.2 Хөрс ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөө:

Уурхайн олборлолтын болон бусад төрлийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийн эх үүсвэр нь:

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

- Олборлолтын үйл ажиллагаанаас /уурхайн ухаш, хөрсний овоолго, зам, барилга байгууламж барих гэх мэт/ нийт 3.2 га талбайн хөрсөн бүрхэвч эвдэрч, ургамлан нөмрөг талхлагдана. Өөрөөр хэлбэл 36000 м² хэмжээний талбайн хөрсөн бүрхэвч нөмрөг талхлагдана.
- Хөрсний овоолгод хөрс дарагдах
- Дотоод тээвэрлэлтийн зам нь шугаман элэгдлийн эх үүсвэр болно. Мөн энэхүү элэгдэл нь агаар дахь тоосонцрын эх үүсвэр болж, тоосонцор нь буцаад хөрсөн бүрхэвчийн шинж чанарт сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

3.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөө:

Хүснэгт №. 5 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөө

№	Нөлөөллийн эх үүсвэр	Нөлөөлөлд өртөх талбай нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийн түвшин		
			Бага	Дунд	Их
1	Гадаргын усны урсац, голдирол үзүүлэх нөлөө	Лицензийн хил дотор ямар нэгэн гадаргын уст цэг байхгүй байна.			
2	Газрын доорхи усны нөөц хомсдох	Ордын хайгуулын ажлын гидрогеологийн судалгаагаар 30-60 метрийн гүнд газрын доорхи усны түвшин илрээгүй байна. Уурхайн ашиглалт 50 метрийн гүнтэй байна.			
3	Шатахуун хадгалах, түгээх Засвар үйлчилгээ	Шатах, тослох материал, химийн бодис зэргийн алдагдах, тунадас болон үерийн усаар угаагдан усан орчинг бохирдуулах			
4	Хаягдлын аж ахуй	Хаягдлын аж аухйн талбай хур тунадас болон үерийн усаар угаагдан хаягдалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчин улмаар хөрсний ба гүний усыг бохирдуулах			
Төслөөс гадаргын болон газрын доорх усан үзүүлэх сөрөг нөлөөллийг нийт 4 нөлөөллөөр тооцсон. Нөлөөллийн 50% нь бага, 50% нь дунд зэргийн нөлөөлөлттэй байна.			2	2	

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Хэцүү цав” хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2-р хэсэгт тусгасаны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
- Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Боржигт” ХХК -аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт №. 6 БОМТ нийт зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Зардал (сая.төг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2.2
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Биологийн олон янзын байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	3.8
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	5.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4.0
9	Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ	5.0
10	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах,	-
2025 оны нийт зардал		25.0

Тус төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино Ингэхдээ, төсөл хэрэгжүүлэгч тухайн арга хэмжээ бүрийг хэрэгжүүлж болохуйц, бодиттой арга хэмжээг төлөвлөн тусгахыг эрхэм болголоо. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2025 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **25,000,000** зарцуулахаар төсөвлөгдсөн байна.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 7 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
								2025 он	
1	Агаарын чанар								
	Уурхайн олборлолт болон тээврийн Хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: -Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны	Уурхайд орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарнилтай уялдуулан оновчтой байлгах тооцоог хийж мөрдөж ажиллах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	Агаарын тухай хууль Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 MNS(ISO)13688:2000
		Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хийх	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	MNS3306:1991 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	ажил, -Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох -Тэсэлгээний ажлын үед үүсэх тоосжилт Ажиллагсад болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	Хүнд машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол байлгах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах	Үйл ажиллагаан ы турш	-		-		+	Бензинхөдөлгүүр т MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
		Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хушуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах сургалт явуулах	Үйл ажиллагаан ы турш	-		-	-	+	
2	Хөрсөн бүрхэвч								
	Ордын ашиглалтын явцад хөрсний	Өнгөн хөрсийг хуулан авах, хадгалах	Үйл ажиллагаан ы турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	“Газрын тухай” хууль

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх. Шатах тослох материал, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Уурхайн олборлолт явуулж буй хэсэгт тэмдэгжүүлэх	Үйл ажиллагааны турш	-		-	200.0	+	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэх, сул шороо бүхий	Төслийн талбай дахь сул шороо бүхий газруудыг	Төслийн талбайд	-		-	Нөхөн сэргээх арга хэмжээнд тусгав	+	MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	газруудаас тоос босох	ургамалжуулах, мод бут тарих							Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS
3	Усны нөөц, усны чанарт								
		Ажилчдын аюулгүй ажиллагааны дүрэмд усыг ариг гамтай хэрэглэх, хамгаалах тухай тусгаж өгөх	Ажилчдад	-		-	Осол эрсдэлийн менежментийн зардалд	+	
		Ажилчдын унд ахуйн усанд ашиглаж байгаа гүний худагаас дээж авч шинжилгээ хийлгэж, усны найрлагыг тодорхойлуулж, ундны усны стандартад нийцэж буйг хянаж байх	Ажилчдын байрны хүрээнд	-		-	Орчны хяналт шинжилгээний зардалд	Сард удаа 1	
4	Амьтны аймаг, ургамлан нөмрөг								

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Үйл ажиллагаа явуулсантай амьтны нөөц хомсдох, ухсан нүх шуудуунд мал амьтан унахаас сэргийлэх	Уурхайн талбайд мал, амьтан унаж гэмтэхээс сэргийлэх зорилгоор хашаа хамгаалалт хийх	Уурхайн хүрээнд	-		-	1,000.0	+	
Хог хаягдлыг ангилан ялгах хогын сав байршуулах	Хог хаягдалыг ил задгай хаяж хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтад үржих, хордох нөхцөл бүрдүүлэхгүй байх	Уурхайн хог хаягдлын хүрээнд	-		-	Хог хаягдлын менежментийн зардалд	+	Хог хаягдлын тухай хууль 2017 он
Уурхайгаас олборлох, хөрс хуулах зэрэг ажлын үед ургамал устах, дарагдах талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Уурхайн тосгоны эргэн тойронд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Уурхайн тосгоны хүрээнд	-		-	1,000.0		

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

5	Дуу чимээ							
	Нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах	Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх		-		-	-	+
Нийт			2200.0 сая.төг					

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ордын уул техникийн нөхцөлөөр далд уурхайн аргаар хүдэр хоршоолох ашиглалтын системээр олборлодог. Ордын уул техникийн нөхцөлөөр 2025 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх боломжгүй байна. Иймээс нөхөн сэргээлтийг дүйцүүлэн хамгаалах ажлаар хийж гүйцэтгэхээр төлөвлөлөө.

БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 8 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг	Нийт зардал /сая.төг/	Баримтлах эрхзүйнбаримт бичиг,стандарт аргачлал
					2025		
1	ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ						
	Зохион байгуулалтгүй аялал жуулчлал, зүй бус ашиглалтаас Байгалийн үзэсгэлэнт газруудын орчин хог хаягдлаар бохирдож, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр олон салаа зам гарч, байгалийн унаган төрх алдагдаж байна.	Тус сумын удирдлагуудтай зөвшилцөн уул уурхай, дэд бүтцийн нөлөөгөөр эвдрэлд орж орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх	Үйл ажиллагааны эхэнд		-	ҮА-ний зардалд (ДХ ажлын зардал)	MNS 5914:2015, MNS 4597:2013

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд	Сумын удирдлагуудтай зөвшилцөн мод тарих	Үйл ажиллагааны эхэнд	Судалгаа хийх, Санхүүжүүлэх			
Нийт дүн, мян.төг			3.8 сая.төг				

БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 онд тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө тусгагдаагүй болно.

БҮЛЭГ 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна. Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгана.

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт №. 9 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал (мян\төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх, арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Нийт ажиллах хугацаанд уурхайн бүх ажилчдад	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан	2025 он	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	
	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Төслийн бүхий л үед хэрэгжүүлэх ХХАА-ны гарын авлагатай болох	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан	2025 он		
	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох	Ус, элс, шороо, хүрз цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт	2	2,000.0	2025 он		
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших		-	1,000.0	2025 он		
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах		12				

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	-			
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	-			
Эрүүл мэнд	Ажилчдыг ажлын хувцас хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинен гутал, бээлий, хамгаалалтын нүдний шил маск) хангах	Бүх ажилчдад	1,000.0	2025 он	
	Хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг нарийвчлан мэргэжлийн байгууллагаар тогтоолгох	Төслийн нийт хугацаанд	1,000.0	2025 он	
Нийт зардал (мян.төг)			5,000.0		

БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 10 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт, стандарт
							2025 он	
Хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдол	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагаа ны турш				1,000.0	+	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011
Ахуйн хатуу хог хаягдлаар газрын гадарга бохирдох;	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.	Төслийн талбайн бүх барилга байгуулам жуудад				1,000.0	+	Хог хаягдлын тухай хууль
Хог хаягдал, ШТМ-ын хаягдал хурын усаар дамжин гүний усыг бохирдуулах	Унд ахуйн усыг лабораторын шинжилгээнд тогтсон хуваарийн дагуу шинжлүүлж байх	Төслийн талбай дахь худгийн усанд				ОХШХ-т тусгасан аар	+	MNS 3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

								талбарт нь шинжилгээ хийх MNS 0900:2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Стандарт нийцсэн усаар хангах	Ундны усны стандарт хангасаар усаар ажилчдад үйлчлэх	Ундны усны хүрээнд				1,000.0	+	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлаг түүнд тавигдах шаардлага MNS 0900:2018
Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх харьяа нийтийн үйлчилгээний албатай хог	Ахуйн хатуу, шингэн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, ажилчидын бие засах газар болон бохир ус хуримтлуулах цэгийг холбогдох хууль, стандартын шаардлагад нийцүүлэн хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй байхаар	Ахуйн хаягдлын хүрээнд				1,000.0	+	Усны тухай хууль, 2012 он Гүний усыг бохирдолоос хамгаалах ерөнхий

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

хаягдлын гэрээ хийх	төлөвлөн шинээр байгуулах, үүссэн шингэн хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах							шаардлагууд MNS 3342:1982
	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр. Гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх					1,000.0		
Нийт		5,000.0мян.төг						

БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт №. 11 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж 2025 он	Давт амжи йн тоо	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Хөрсний бохирдол								
1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт , давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүү н, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 2 цэг сонгох /Уурхайн кемп орчим, уурхайн ухаш/	Хагас жил тутамд	Жилд 2 удаа	1,000.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1жил /15.0/ НИЙТ 120,0 /Хөрсний химийн шинжилгэ э 1 дээж - 15.0 төг,	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	2 цэгт /Засварын цех, ШТС/	Хагас жил тутамд	Жилд 2 удаа	1,000.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1 жил х 20,0 Нийт 160,0 хүнд металлын шинжилгээ 1 дээж-20.0 төг/	MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
		Усны хяналт шинжилгээ						
2	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	2025 он	Жилд 2 удаа	1,000.0	40.0*2 удаа х 1жил НИЙТ 80.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт
3	Усны түвшин усны	Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар	Гүний худгийн ус, Гол	2025 он		1,000.0		MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	ундарга нөөц	доорх усны горим өөрчлөгдөх						
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2025 ОНЫ ЗАРДЛЫН ДҮН					4,000.0			

БҮЛЭГ 13. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт №. 12 БОМТ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Зардал мян.төг	Хугацаа 2025 он
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	Уурхайн хэмжээнд	1,000.0		2025 он
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	Уурхайн хэмжээнд	1,000.0		2025 он
4	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлыг жил бүрийн тайланг БОАЖЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх	Уурхайн хэмжээнд	1,000.0		Жил бүрийн 12 сард
5	Байгаль хамгаалахад сум багийн холбогдох ажилтнуудын оролцоог идэвхижүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах	Уурхайн хэмжээнд	1,000.0		2025 он
6	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө	Уурхайн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр		2025 он

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХЭЦҮҮ ЦАВ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

7	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгслийг бэлтгэж, шаардлагатай газруудад байрлуулах	Уурхайн хэмжээнд	-	-	2025 он
8	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах сургалт зохион байгуулах, галын аюулгүй ажиллагааны талаар дүүргийн ГТТХХэлтэстэй хамтран галын аюулаас урьдчилан сэргийлэх үзүүлэх сургууль хийх	Уурхайн хэмжээнд	Ослын сургалттай хамтран хэрэгжүүлэх		3-р улирал
9	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Улирал бүр
10	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах	Уурхайн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүр
11	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	Уурхайн хэмжээнд	1,000.0		Жилд 2 удаа
12	Галын аюулгүй байдлын дүгнэлтийг дүүргийн Онцгой байдлын хэлтсээр гаргуулах	Дотоод төлөвлөлтөөр			Жилд 1 удаа
13	Нийгмийн хариуцлагын хүрээнд багын иргэдэд цагаан сар болон бусад үйл ажиллагааг дэмжих үүднээс тусламж өгөх	Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн гэрээгээр			2025 он
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал				5,000.0 мян.төг	

**БҮЛЭГ 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ
ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ**

Хүснэгт №. 13 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Дорноговь аймгийн сумдын ажлын хэсэгт танилцуулах	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумын засаг захиргаанд хүргүүлнэ	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	2025.11.01-нд хүргүүлэх	-	“Боржигт” ХХК - ын байгаль орчны мэргэжилтэн	
Нийт		220.0 мян.төг				